

ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ (ЖДҮ)-Г БЛОКЧЭЙН ТЕХНОЛОГИОР ДААТГАХ НЬ (ISBC)



Төслийн тухай

Монгол Улс нь ОХУ, БНХАУ-ын дунд орших далайд гарцгүй, Зүүн Азид оршдог бөгөөд цаг агаарын эрс тэс уур амьсгал, цаг агаарын хүнд үзэгдлүүдэд байнга өртдөг улсын нэг болно. 2000 оноос хойш цаг агаарын эрс тэс уур амьсгалтай холбоотой аюултай ноцтой байдлын тоо нэмэгдэж байна. Хот суурин газарт аадар бороо, цас орсны улмаас үер усны аюул нэмэгдэж, барилга байгууламж, дэд бүтцийг сүйтгэж, гал түймэр гарах нь гамшгийн эрсдэл юм. Эдгээр эрсдэлүүд нь зөвхөн хувийн орон сууцанд төдийгүй бизнесийн ажлын байранд ч хамаатай юм.

Хугацаа	2021-2023
develoPPP хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлэгч байгуулага	Монре Даатгал
Санхүүжүүлэгч	ХБНГУ-ын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (BMZ)



Төслийн бүс нутаг



Зорилго

“Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг (ЖДҮ)-г даатгалаар дамжуулан цаг агаарын эрс тэс уур амьсгалтай холбоотой эрсдэлийг бууруулах мэдлэг, чадварыг сайжруулах.

Арга барил

Энэхүү төсөл нь “Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг блокчэйн технологиор даатгах нь” (ISBC) жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-д зориулсан цаг агаарын индексийн даатгалын бүтээгдэхүүн боловсруулж, түрших ба блокчэйн технологид суурилсан ЖДҮ-ийн эрсдлийн зураглалыг төлөвлөнө. Даатгалын бүтээгдэхүүн нь ЖДҮ-ийн үер, гал түймрийн улмаас учирсан хохирлыг нөхөх зорилготой төдийгүй банкны зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ. Даатгалын ийм бүтээгдэхүүн нь банкны нэмэлт барьцаа болж өгдөг тул банкны зээлийн эрсдэлийг бууруулдаг. Энэхүү түршилтын бүтээгдэхүүн нь даатгалын зах зээл дэх бусад оролцогч талуудыг шинэ, шинэлэг технологи ашиглан эрсдэлийг бууруулах нэмэлт (цаг уурын) бүтээгдэхүүн боловсруулах, зорилтот бүлгийн эрсдэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд түлхэц болно.



Үр дүнгүүд

Үр дүн 1 Монгол улсын ЖДҮ-д учирч буй эрсдэлийн талаарх мэдлэг нэмэгдэнэ.

- Дотоодын зөвлөлтэй хамтран ЖДҮ эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл байдал, эрсдэлийн талаарх мэдлэгийг ойлгох суурь судалгааг хийсэн.
- Суурь судалгаанд 400,000 ЖДҮ эрхлэгчид хамрагдсан.
- Та блокчэйн суурилсан даатгалын үйлчилгээг дэмжих giz.de сайтаас Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг блокчэйн

технологоор даатгах нь суурь судалгааг татаж авах боломжтой.



Зураг 1: Суурь судалгааны фокус бүлгийн ярилцлага

Үр дүн 2 Үерийн даатгалын индексжүүлсэн бүтээгдэхүүн боловсруулах, түрших.

- Олон улсын актуарчтай хамтран индексжүүлсэн үерийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулсан.
- Хиймэл дагуулын өгөгдөл голчлон бүтээгдэхүүн боловсруулах, түүнчлэн Цаг уур, орчны шинжилгээний газраас цуглуулсан түүхий мэдээлэлд ашигладаг.
- Шинэ бүтээгдэхүүн нь одоогоор Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн байгаа бөгөөд бүртгүүлсний дараа манай хамтран төсөл хэрэгжүүлэгч түншээс бүтээгдэхүүнийг авах боломжтой болно.

Үр дүн 3 Эрсдэлийн зураглалын системийг хөгжүүлэх.

- Эрсдэлийн зураглалыг олон нийтэд нээлттэйгээр хөгжүүлсэнээс ямар ч хүн өөрийн эрсдэлийг үнэлэх боломжтой болох юм.
- Одоогийн байдлаар Онцгой байдлын ерөнхий газрын мэргэжилтнүүдтэй хамтран үер, гал түймрийн эрсдэлийн энгийн загварчлалын судалгааны ажлыг хийсэн.

- Энэхүү бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, иргэдийг үерийн бүсэд бизнес эрхлэх, оршин суухаас сэргийлнэ.

Үр дүн 4 Эрсдэл, даатгалын мэдлэг олгох кампанит ажил

- Мэдлэг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөөнд хамрагдсаны дараа ЖДҮ эрхлэгчид эрсдэл, даатгалын талаарх мэдлэг нэмэгдэнэ.
- ЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалтыг видео, тоглоом гэх зэрэг интерактив аргаар зохион байгуулна.
- Даатгалын салбарын хувьд актуарч, андеррайтерийн сургалт зохион байгуулна.
- Сургагч багш нар нь СИ шалгалтад тэнцсэн хүмүүс байх болно.
- Сургалтын төгсгөлд даатгалын салбарын ажилчид эрсдэлийн талаар мэдлэгтэй болно. Энэхүү мэдлэгийг олон нийтэд түгээх боломжтой болно.



Зураг 2: Лайка бүтээгдэхүүний нээлт



Зураг 3: Лайка бүтээгдэхүүний нээлт - сургалт

Published by Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH
Registered offices Bonn and Eschborn, Germany

Insuring Small and Medium Enterprises through Blockchain Technology Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг (бждү)-г блокчэйн технологоор даатгах нь (isbc)

United Nations Street, Building #38, 3rd Floor
4th Khoroo, Chingeltei District,
Ulaanbaatar 210646, Mongolia
T +976 7011 7704
<https://www.giz.de/en/worldwide/94825.html>

Photo credits List of photographers in alphabetical order
Photographer a:

Text Jutta Rehag

GIZ is responsible for the content of this publication.

On behalf of Federal Ministry for Economic Cooperation and Development (BMZ)

In cooperation with

As at June 2023

Printed by Ulaanbaatar

Design GIZ Mongolia, Ulaanbaatar